



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/139

Бор-Өндөр сум


**Эрсдэлийн сангаас хөрөнгө зарцуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалт, Бор-Өндөр сумын Онцгой комиссын 2025 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 3 дугаар цэцэрлэгийн ахлах А, Б бүлгийн ангийн ариун цэврийн өрөөний бохирын далд шугамны труба задарч доод анги руу бохирын ус нэвчиж, хүнд нөхцөл байдал үүссэн тул засварын зардалд 2,403,000 (хоёр сая дөрвөн зуун гурван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 2,403,000 (хоёр сая дөрвөн зуун гурван мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Эрсдэлийн сангаас зохих журмын дагуу тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ